



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 78

Номгон

Г

Үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийн
дуудлагын худалдааны доод үнийг
шинэчлэн тогтоох тухай

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтын 2 дугаар мөрөнд заасан Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй kontорын хуучин барилгын худалдах доод үнийг 50 хувиар бууруулж 13 478 000 төгрөг; Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 27 дугаар тогтоолын хавсралтын барилга байгууламж хүснэгтийн 2 дугаар мөрөнд заасан Богд сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Цэлгэр 4 дүгээр багийн төвийн барилгын худалдах доод үнийг 20 хувиар бууруулж 1160000 төгрөг; Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 14 дугаар тогтоолын хавсралтын 3 дугаар мөрөнд заасан Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 77-03 БНХ улсын дугаартай Ланд круизер-100 маркийн автомашины худалдах доод үнийг 50 хувиар бууруулан 4472500 төгрөг; Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 122 дугаар тогтоолын 2 дугаар заалтад заасан Заг сумын цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1970 онд ашиглалтад орсон 18592000 төгрөгийн анхны үнэтэй хуучин цэцэрлэгийн барилгын худалдах доод үнийг 50 хувиар бууруулж 3000000 /Гурван сая/ төгрөгөөр тогтоож дахин дуудлагын худалдааг зохион байгуулж орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх шаардлагатайг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам"-ын 2.2, 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй конторын хуучин барилга, Богд сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Цэлгэр 4 дүгээр багийн төвийн барилга, Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 77-03 БНХ улсын дугаартай Ланд Круйзер-100 маркийн автомашин, Заг сумын цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1970 онд ашиглалтад орсон 18592000 төгрөгийн анхны үнэтэй хуучин цэцэрлэгийн барилгыг тус тус нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Барилга, автомашины нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 11⁰⁰ цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 103 тоот өрөөнд зохион байгуулж орлогыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх;

2.2 Худалсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 08 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

